

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2022/161/НА-СТА-ТШЗ**

---

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа  
Утас: 93032714

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

---

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	12
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт .....	13
4.3 Албан шаардлага.....	13
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2022.03.09 № 136  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Г

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны ЕБС-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Гурванбаян тосгоны ЕБС-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин 1,750.0 мянган төгрөгийг зарцуулсан, батлагдсан төсвөөс үндэслэлгүй 7,465.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь оршин байх, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

023030221


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>78,498,320.91</b>	<b>72,613,565.08</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,500,000.00</b>	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,500,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>76,998,320.91</b>	<b>72,613,565.08</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,752,800.00</b>	<b>1,572,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	1,273,000.00	1,242,000.00
35130	Эм боох материал	479,800.00	330,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	25,149,646.65	25,149,646.65
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>41,350,874.26</b>	<b>37,401,918.43</b>
35410	Бичиг хэргийн материал	9,860,081.76	8,179,833.13
35420	Аж ахуйн материал	15,600,362.50	17,166,237.50
35430	Сэлбэг хэрэгсэл	1,560,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	2,950,000.00	1,613,200.00
35450	Барилгын засварын материал	973,000.00	2,337,400.00
35460	Хүнсний материал	7,520,300.00	7,139,417.80
35470	Бусад хангамжийн материал	2,887,130.00	965,830.00
35600	Мал амьтад	8,745,000.00	8,490,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>629,154,688.15</b>	<b>1,034,403,053.67</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>629,154,688.15</b>	<b>1,034,403,053.67</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>593,502,688.15</b>	<b>998,751,053.67</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	639,491,304.00	1,052,887,516.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(100,225,914.24)	(133,693,800.73)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,000,000.00	7,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,666,666.56)	(5,541,666.54)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	74,953,693.05	96,232,564.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,820,828.49)	(43,964,127.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,243,687.11	59,113,240.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	(46,138,307.52)	(42,719,407.14)
39217	Ном	8,665,720.80	9,436,734.36
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>35,652,000.00</b>	<b>35,652,000.00</b>
39301	Програм хангамж	760,000.00	760,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(760,000.00)	(760,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	35,652,000.00	35,652,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>707,653,009.06</b>	<b>1,107,016,618.75</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,500,000.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,500,000.00</b>	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>1,500,000.00</b>	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	150,000.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>1,350,000.00</b>	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,350,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>706,153,009.06</b>	<b>1,107,016,618.75</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>706,153,009.06</b>	<b>1,107,016,618.75</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>232,342,419.07</b>	<b>232,342,419.07</b>
51101	Өмч: - төрийн	232,342,419.07	232,342,419.07
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>61,291,403.38</b>	<b>462,155,013.07</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	61,291,403.38	61,291,403.38
51220	Тайлант үеийн үр дүн	-	400,863,609.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	412,519,186.61	412,519,186.61
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>707,653,009.06</b>	<b>1,107,016,618.75</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>527,165,555.60</b>	<b>952,600,876.93</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,859,155.60</b>	<b>424,221,251.93</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,859,155.60</b>	<b>424,221,251.93</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,859,155.60	424,221,251.93
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,859,155.60	424,221,251.93
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>522,306,400.00</b>	<b>528,379,625.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	436,392,400.00	440,299,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	436,392,400.00	440,299,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,605,125.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,605,125.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,914,000.00	83,475,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,914,000.00	83,475,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>570,338,131.58</b>	<b>551,737,267.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>570,338,131.58</b>	<b>551,737,267.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>524,445,156.39</b>	<b>486,689,601.17</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,445,465.00	304,730,377.00
210101	Үндсэн цалин	211,457,303.00	215,761,679.00
210102	Нэмэгдэл	72,434,323.00	65,212,116.00
210104	Урамшуулал	24,553,839.00	23,756,582.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,400,178.81	40,542,757.93
210201	Тэтгэврийн даатгал	27,062,360.25	28,353,542.85
210202	Тэтгэмжийн даатгал	3,084,454.64	3,047,303.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,467,563.71	2,437,843.01
210204	Ажилгүйдлийн даатгал	616,890.93	609,460.76
210205	Эрүүл мэндийн даатгал	6,168,909.28	6,094,607.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,530,164.00	81,458,389.00
210301	Гэрэл, цахилгаан	2,762,097.00	3,927,669.00
210302	Түлш, халаалт	71,028,067.00	76,180,720.00
210303	Цэвэр, бохир ус	740,000.00	1,350,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,739,786.40	4,069,425.00
210401	Бичиг хэрэг	4,918,633.70	944,500.00
210402	Тээвэр, шатахуун	560,000.00	940,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	175,000.00	125,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	38,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,047,652.70	2,059,925.00
2105	Нормативт зардал	9,425,256.00	5,907,792.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54,700.00	96,800.00
210502	Хоол, хүнс	9,044,656.00	5,810,992.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	325,900.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,823,520.00	2,932,600.00
210604	Урсгал засвар	1,823,520.00	2,932,600.00
2107	Томилолт, зочны зардал	4,823,000.00	1,583,200.00
210702	Дотоод албан томилолт	4,823,000.00	1,583,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	720,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,933,786.18	44,745,060.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	525,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,547,150.00	4,082,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,386,636.18	40,137,360.04
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>45,892,975.19</b>	<b>65,047,666.07</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,369,310.00	14,702,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,269,310.00	6,502,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,100,000.00	8,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,057,836.00	824,311.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,057,836.00	824,311.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,465,829.19	49,520,555.07
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,465,829.19	49,520,555.07
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(43,172,575.98)</b>	<b>400,863,609.69</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(43,172,575.98)</b>	<b>400,863,609.69</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>522,306,400.00</b>	<b>528,379,625.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>522,306,400.00</b>	<b>528,379,625.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>436,392,400.00</b>	<b>440,299,400.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	436,392,400.00	440,299,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>4,605,125.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,605,125.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>85,914,000.00</b>	<b>83,475,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,914,000.00	83,475,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>522,306,400.00</b>	<b>528,379,625.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>522,306,400.00</b>	<b>528,379,625.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>474,285,734.81</b>	<b>465,184,558.93</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>308,445,468.00</b>	<b>304,730,377.00</b>
210101	Үндсэн цалин	204,800,939.00	208,063,733.00
210102	Нэмэгдэл	79,090,690.00	71,856,831.00
210104	Урамшуулал	24,553,839.00	24,809,813.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,400,175.81</b>	<b>40,542,757.93</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,062,361.27	28,353,540.17
210202	Тэтгэмжийн даатгал	3,084,453.49	3,047,304.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,467,564.20	2,437,843.42
210204	Ажилгүйдлийн даатгал	616,892.29	609,461.02
210205	Эрүүл мэндийн даатгал	6,168,904.56	6,094,608.88
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>76,165,164.00</b>	<b>80,548,389.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,762,097.00	3,927,669.00
210302	Түлш, халаалт	72,663,067.00	75,270,720.00
210303	Цэвэр, бохир ус	740,000.00	1,350,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,439,175.00</b>	<b>4,824,825.00</b>
210401	Бичиг хэрэг	833,400.00	741,525.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	513,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	125,000.00	125,000.00
210404	Ном, хэвлэл	66,700.00	66,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	554,300.00	54,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,659,775.00	3,324,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>10,038,180.00</b>	<b>5,659,810.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,400.00	48,400.00
210502	Хоол, хүнс	9,271,780.00	5,361,410.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	718,000.00	250,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,841,000.00</b>	<b>24,302,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	22,198,000.00
210602	Тавилга	4,500,000.00	-
210604	Урсгал засвар	7,341,000.00	2,104,400.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>4,673,000.00</b>	<b>1,583,200.00</b>
210702	Дотоод албан томилот	4,673,000.00	1,583,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>324,000.00</b>	<b>720,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	720,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,959,572.00</b>	<b>2,272,800.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	926,800.00	184,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,032,772.00	2,088,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>48,020,665.19</b>	<b>63,195,066.07</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,997,000.00</b>	<b>12,850,200.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,897,000.00	4,650,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,100,000.00	8,200,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,407,836.00</b>	<b>824,311.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,407,836.00	824,311.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>39,615,829.19</b>	<b>49,520,555.07</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,615,829.19	49,520,555.07
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>C01</b>	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>232,342,419.07</b>	<b>412,519,186.61</b>	<b>61,291,403.38</b>		<b>706,153,009.06</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	232,342,419.07	412,519,186.61	61,291,403.38	-	706,153,009.06
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
<b>C08</b>	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>232,342,419.07</b>	<b>412,519,186.61</b>	<b>61,291,403.38</b>	-	<b>706,153,009.06</b>
<b>D01</b>	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>232,342,419.07</b>	<b>412,519,186.61</b>	<b>61,291,403.38</b>	-	<b>706,153,009.06</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	232,342,419.07	412,519,186.61	61,291,403.38	-	706,153,009.06
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	400,863,609.69	-	400,863,609.69
<b>D09</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>232,342,419.07</b>	<b>412,519,186.61</b>	<b>462,155,013.07</b>	-	<b>1,107,016,618.75</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>523,774,500.00</b>	<b>473,431,633.93</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>523,774,500.00</b>	<b>473,431,633.93</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>507,710,500.00</b>	<b>460,581,433.93</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>340,272,100.00</b>	<b>304,730,377.00</b>
210101	Үндсэн цалин	201,540,300.00	208,063,733.00
210102	Нэмэгдэл	112,987,800.00	71,856,831.00
210104	Урамшуулал	25744000.00	24809813.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>46,540,600.00</b>	<b>40,542,757.93</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,899,800.00	28,353,540.17
210202	Тэтгэмжийн даатгал	3,410,200.00	3,047,304.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,728,200.00	2,437,843.42
210204	Ажилгүйдлийн даатгал	682,000.00	609,461.02
210205	Эрүүл мэндийн даатгал	6,820,400.00	6,094,608.88
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>81,370,700.00</b>	<b>80,548,389.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,500,000.00	3,927,669.00
210302	Түлш, халаалт	73,870,700.00	75,270,720.00
210303	Цэвэр, бохир ус	2000000.00	1350000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,306,500.00</b>	<b>4,306,500.00</b>
210401	Бичиг хэрэг	583,200.00	583,200.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	125,000.00	125,000.00
210404	Ном, хэвлэл	66,700.00	66,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	54,300.00	54,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,177,300.00	3,177,300.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>10,427,000.00</b>	<b>5,659,810.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,400.00	48,400.00
210502	Хоол, хүнс	10,126,400.00	5,361,410.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	252,200.00	250,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>21,604,400.00</b>	<b>21,604,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,500,000.00	19,500,000.00
210604	Урсгал засвар	2,104,400.00	2,104,400.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,583,200.00</b>	<b>1,583,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,583,200.00	1,583,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>904,400.00</b>	<b>720,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	184,400.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>701,600.00</b>	<b>886,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	184,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	701,600.00	701,600.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,064,000.00</b>	<b>12,850,200.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,064,000.00</b>	<b>12,850,200.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,864,000.00	4,650,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,200,000.00	8,200,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>523,774,500.00</b>	<b>473,431,633.93</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>440,299,400.00</b>	<b>390,778,844.93</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	440,299,400.00	390,778,844.93
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>83,475,100.00</b>	<b>82,652,789.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	83,475,100.00	82,652,789.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,605,125.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,605,125.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,603,125.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>518,325.00</b>
210401	Бичиг хэрэг	158,325.00
210402	Тээвэр, шатахуун	213,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	146,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,698,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,698,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,386,800.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,386,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,000.00</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,000.00</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	2,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,605,125.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,605,125.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,507,125.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	98,000.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт нь хүмүүнлэг, оюунлаг, эрүүл чийрэг, зөв амьдрах чадвартай иргэн төлөвшүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Боловсролын газраас болон Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд тус байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванбаян тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын

үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 481.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 399.4 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1.5	-	1.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	77.0	72.6	4.4
Үндсэн хөрөнгө	629.2	1,034.4	(405.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>707.7</b>	<b>1,107.0</b>	<b>(399.4)</b>
Өр төлбөр	1.5	-	1.5
Засгийн газрын оролцоо	706.2	1,107.0	(400.9)
Засгийн газрын оролцоо /Өмч-Төрийн/	232.3	232.3	-
Өмнөх үеийн үр дүн	61.3	61.3	-
Тайлант үеийн үр дүн	-	400.9	(400.9)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	412.5	412.5	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>707.7</b>	<b>1,107.0</b>	<b>(399.4)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 4.4 сая төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 405.2 сая төгрөгөөр өссөн нь дотуур байрны их засварыг капиталжуулсантай холбоотой байна.

Авлага, өр төлбөр дансны үлдэгдэл 1.5 сая төгрөгөөр буурч бүрэн барагдсан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,107.0 сая төгрөг болж, 400.9 сая төгрөгийн тайлант оны үр дүнгээр нэмэгдсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 425.4 сая төгрөгөөр буюу 80.7 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь улсын төсвийн санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 18.6 сая төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан нь цалин хөлс, хангамж, бараа материалын зардалтай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 569.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 45.7 сая төгрөгөөр бууруулан 523.8 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг тусгай зориулалтын шилжүүлгээс 440.3 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 83.5 сая төгрөгөөр нийт 523.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 440.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 83.5 сая төгрөг нийт 523.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 473.4 сая төгрөг зарцуулж, 49.6 сая төгрөгийг улсын төсөвт, 0.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 4.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.1 сая төгрөг нийт 4.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Онцлох асуудал байхгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитаар илэрсэн гол асуудал байхгүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийг шалгахад 101.6 сая төгрөгийн 3 худалдан авалтыг, 499.5 сая төгрөгийн 20 орлогын, 90.2 сая төгрөгийн 8 зарлагын мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах 1 зөвлөмж өгсөн нь бүрэн хэрэгжсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг үндсэн хөрөнгө тус бүрээр авч үзэх болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 9.2 сая төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс 2 албан шаардлага хүргүүлсэн.

#### **4.1 Залруулсан алдаа**

Залруулга хийгдээгүй.

#### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй.

#### **4.3 Албан шаардлага**

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас 1.8 сая төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэсэн.

Батлагдсан төсвөөс үндэслэлгүйгээр 7.5 сая төгрөгийн тэтгэмж олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан.

#### **4.4 Зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны ЕБС	2	9.2					2	9.2		
<b>ДҮН</b>		<b>2</b>	<b>9.2</b>					<b>2</b>	<b>9.2</b>		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 76/А2370448  
ХЭА 2022/161/НА СТА-ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг Гурванбаян тосгоны ЕБС-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвөөс үндэслэлгүйгээр 7,465.0 мянган төгрөгийн тэтгэмж олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гурванбаян тосгоны ЕБС-ийн захирал Я.Сүхбаатар, нягтлан бодогч Ч.Уянганэмэх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 77/А2370/МН8  
ХТХ-2022/161/НА-СТА-ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг Гурванбаян тосгоны ЕБС-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин бага үнэтэй түргэн элэгдэх зүйлээс 1,750.0 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэсэн.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гурванбаян тосгоны ЕБС-ийн захирал Я.Сүхбаатар, нягтлан бодогч Ч.Уянганэмэх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА



02504 383